



## №5.7 ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ ХЭРЭГЛЭГЧИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС

Хяналтын байгууллага:

Шалгуулагч этгээдийн нэр:

Объектын нэр:

Регистрийн дугаар:

Хяналт шалгалт хийсэн огноо:...../...../.....

Шаардлага хангасан  
асуултын тоо:

Хууль сахин  
мөрдөлтийн хувь:

Шаардлага хангаагүй  
нийт оноо:

Эрсдэл үүсэх  
магадлалын хувь:

Эрсдэл үүсэх  
магадлал

### ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Батлагдсан оноо		Авсан оноо	Гүйцэтгэлийн шалгалт
			Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй		
1		2	3	4	5	6
<b>I. Хэсэг Холбогдох зөвшөөрөл, зураг төсөл, баримт бичгийн бүрдүүлэлт</b>			<b>0</b>	<b>165</b>		
1.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 1.3	Хангагч байгууллагаас техникийн нөхцөл авсан	0	30		
2.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.2	Дулаан дамжуулах төв, дулааны узель, гадна дулааны шугам, тоног төхөөрөмжийн иж бүрэн батлагдсан зураг төсөлтэй	0	30		
3.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 4-р зүйл	Хангагч байгууллагатай дулааны эрчим хүчээр хангах, хэрэглэх гэрээ байгуулсан	0	20		
4.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.2	Тоног төхөөрөмжийн паспорттай, түүний хөтлөлт баяжилт хийгддэг	0	5		
5.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.2	Тоног төхөөрөмжийн ашиглалт аюулгүй ажиллагааны батлагдаж хянагдсан заавартай, технологийн схем зургийг ажлын байранд байрлуулсан	0	5		
6.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.2	Ашиглалт, засвар болон аюулгүй ажиллагааны дүрэм, журмаар хангагдсан, мөрдөж ажилладаг	0	5		

7.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.11	Хяналтын болон хангагч байгууллагын шалгалтаар илэрсэн техник ашиглалт, аюулгүй ажиллагааны зөрчлийг арилгасан, шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлсэн	0	10		
8.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.12	Ажил үүргээ гүйцэтгэж байгаа эрчим хүчний улсын байцаагч болон хангагчийн төлөөлөгчийг өөрийн эзэмшлийн газарт саадгүй нэвтрүүлж, дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээгээ шалгуулдаг	0	5		
9.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.16	Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм болон холбогдох бусад дүрэм, журмыг мөрдөж ажилладаг	0	20		
10.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.18	Нийтийн эзэмшлийн орон сууцны барилгын хувьд дулаан дамжуулах төв, дамжуулах, түгээх шугам, тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлсэн	0	10		
11.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.20	Дулаан дамжуулах 200 мм-ийн голчтой болон түүнээс дээш голчтой төв шугам, салаа шугамыг төрийн өмчид шилжүүлсэн	0	10		
12.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.1	Дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний ашиглалт, засварыг хариуцах мэргэжлийн ажилтантай, мэргэжлийн ажилтны мэдлэг чадварыг тогтмол дээшлүүлдэг	0	10		
13.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 1.5	Дулаан түгээх шугам сүлжээг барихад гаргасан хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэн уг шугам сүлжээний эзэмшлийн заагийг өмчийн харьяаллаар тогтоосон	0	5		
<b>II. Хэсэг Техникийн бүрэн бүтэн байдал</b>			<b>0</b>	<b>185</b>		
14.	Барилгын тухай хуулийн 14.1.1	Дулаан дамжуулах төв, дулааны узель, гадна дулааны шугам, тоног төхөөрөмж нь батлагдсан зураг төслийн дагуу угсрагдсан	0	20		
15.	Эрчим хүчний тухай хуулийн 30.1.8	Өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангуулсан, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцдаг	0	50		
16.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.2	Дулааны шугамууд нь ялгарах өнгөөр будагдсан, тоног төхөөрөмж, хаалт арматурт бирк, бичилт хийгдсэн	0	5		
<b>Засвар үйлчилгээ</b>						
17.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.3	Дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний ээлжит их болон урсгал засварыг дамжуулагч, түгээгчийн төв шугамын засвартай уялдуулж, хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэсэн	0	10		
18.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.7	Өөрийн болон хамтын эзэмшлийн дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээнд гэмтэл гарсан тохиолдолд хангагчид нэн даруй мэдэгдэж, яаралтай засварлах арга хэмжээ авсан	0	5		
19.	Эрчим хүчний тухай хуулийн 12.1.11	Тоног төхөөрөмж, шугам сүлжээний угсралт, засварын ажлыг эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар гүйцэтгүүлсэн	0	10		
<b>Насос, хөдөлгүүр</b>						

20.	"Дулааны сүлжээ" БНБД 41-02-13-ын 9.2.8	Халаалт, халуун усны насосны ажиллагаа хэвийн, халаалтын бэлтгэл насостой	0	10		
<b>Хаалт, арматур</b>						
21.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.2	Дулааны шугамын ерөнхий оруулга, насосын өмнө болон дараа, бойлер, халаагчийн орох гарах талд хаалт суурилагдсан	0	5		
<b>Хянах хэмжих хэрэгсэл, автоматжуулалт</b>						
22.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.2	Зураг төсөлд заагдсан манамаар, термометр, усны түвшний хэмжүүр тавигдсан, түүний ажиллагаа хэвийн	0	10		
23.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.2	Халаалт, хэрэгцээний халуун усны температур, даралт, нэмэлт усны тоног төхөөрөмжийг автоматаар удирдах болох тохируулах системээр тоноглогдсон	0	10		
24.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.14	Хангагчтай тооцоо хийдэг тоолуурын бүрэн байдлыг хариуцаж, гэмтэл гарсан болон гарч болзошгүй тохиолдолд хангагчид яаралтай мэдэгддэг	0	10		
<b>Хог шүүгч</b>						
25.	Дулааны сүлжээ БНБД 41-02-13-ийн 15.15	Дулааны ерөнхий оруулгын шугам, насос, дулааны тоолуурын өмнө хог шүүгч суурилуулсан	0	5		
<b>Хими ус цэвэрлэгээний төхөөрөмж</b>						
26.	Дулааны сүлжээ БНБД 41-02-13-ийн 15.17	Сүлжээний усны хатуулгийг тогтмол барих хими ус цэвэрлэгээний төхөөрөмж суурилуулсан	0	5		
<b>Шугам хоолойн дулаалга, зэврэлтээс хамгаалах будаг</b>						
27.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.2	Орчны температур 25°C байхад дулаалгын гадаргууд дээрх температур нь 46°C-аас ихгүй байхаар тооцоолон шугам хоолой, дулаан хэрэглэх тоног төхөөрөмжийн гадаргуун хэсэгт дулаан тусгаарлалт хийсэн	0	5		
28.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.2	Тоног төхөөрөмж, шугам хоолой нь зэврэлтээс хамгаалагдсан будгаар будагдсан	0	5		
<b>Юүлэх, агаар гаргах төхөөрөмж</b>						
29.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.2	Дулааны сүлжээний өндөр цэгт агаар гаргах, нам цэгт юүлэх, ус буулгах төхөөрөмжөөр тоноглогдсон	0	5		
<b>Ажлын байр</b>						
30.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.8	Дулаан дамжуулах төв болон зангилааг эмх цэгцтэй, цэвэр, байнгын гэрэлтүүлэгтэй байлгаж, агуулах, орон байрны зориулалтаар ашиглаагүй	0	10		
31.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.2	Дулааны пункт, зангилаа, үзелийн өрөөнд ус зайлуулах трап, ямкатай	0	5		
<b>III. Хэсэг Горим ажиллагаа, туршилт тохируулга</b>			<b>0</b>	<b>35</b>		
32.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.5	Дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээнд тохируулга хийж барилга, орон сууцны өрөө тасалгааг жигд халаасан	0	20		
33.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.4	Дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээндээ химийн болон механик угаалга, цэвэрлэгээ, даралтын туршилт хийсэн	0	10		
34.	"Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5.1.6	Барилга орон сууцыг халааж байгаа сүлжээний усыг бүрэн хэмжээгээр буулгах тохиолдолд хангагчаас зөвшөөрөл авсан,	0	5		

		сүлжээний усыг юүлэх болон бусад зориулалтаар ашиглаагүй				
<b>НИЙТ ОНОО</b>			<b>0</b>	<b>385</b>		

<b>БАТАЛГААЖУУЛАЛТ</b>		
<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан</i>
<i>/ овог, нэр/</i>	<i>/ овог, нэр/</i>	<i>/ овог, нэр/</i>
<i>/ гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/ гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/ гарын үсэг, тамга/</i>

Тайлбар: